# ТАНИЛЦУУЛГА

*Хүнсний барааны үнийн 2019 оны*
*I сарын 09-ний өдрийн ажиглалт*

Нийслэлийн төвийн 6 дүүрэгт байрладаг 12 хүнсний зах, худалдааны төвд хийсэн 32 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн 2019 оны I сарын 2-р долоо хоногийн ажиглалтаар өмнөх долоо хоногтой харьцуулахад 18 нэрийн барааны үнэ тогтвортой, 0 нэрийн барааны үнэ буурсан, 14 нэрийн барааны үнэ өссөн байна. Үүнд :

| ≈ Үнэ тогтвортой | ⇩ Үнэ буурсан | ⇧ Үнэ өссөн |
|---|---|---|
| "Алтан Тариа" задгай гурил дээд | | "Сүү" ХК хайрцагтай 1 л сүү |
| "Алтан Тариа" задгай гурил I | | Цагаан будаа, "Заантай" |
| "Алтан Тариа" савласан гурил дээдийн дээд | | Цөцгийн тос, Сүү ХК |
| "Алтан Тариа" савласан гурил дээд | | Элсэн чихэр, "Заантай" |
| "Алтан Тариа" савласан гурил I | | Хонины мах, ястай |
| "Алтан Тариа" савласан гурил II | | Хонины мах, цул |
| "Сүү" ХК савласан 0.5 л сүү | | Үхрийн мах, ястай |
| Сүү, задгай | | Үхрийн мах, цул |
| Тараг, Цөцгийтэй | | Адууны мах, ястай |
| Талх, "Атар" | | Ямааны мах, ястай |
| Талх, "Зууван чех" | | Төмс, монгол |
| Талх, "хөх тарианы хар" | | Лууван, монгол |
| Шар будаа | | Байцай, монгол |
| Ургамлын тос, "Янта" | | Хүрэн манжин, монгол |
| Ногоон цай, "Стимо" | | |
| Сонгино, хятад, бөөрөнхий | | |
| Алим, фужи | | |
| Өндөг, ОХУ | | |

## Махны дундаж үнэ

2019 оны I сарын 2-р долоо хоногт хонины ястай мах нэг килограмм нь дунджаар 6980 төгрөг, үхрийн ястай мах нэг килограмм нь дунджаар 8745 төгрөгийн үнэтэй байна. Үхрийн ястай махны үнэ өмнөх долоо хоногтой харьцуулахад 165 төгрөгөөр (1.9%), үхрийн цул махны үнэ 90 төгрөгөөр (0.9%) тус тус өссөн байна. Энэ долоо хоногийн ажиглалтаар үхрийн мах "Хархорин" хүнсний захад хамгийн хямд буюу 8000 төгрөг, Харин "Меркури" хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 9500 төгрөг байна.

Зураг 1. Үхрийн махны дундаж үнэ, 1 кг



Хүснэгт 1. Нэг килограмм махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг

**Үхрийн ястай мах**

| | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2013 | 7 335 | 8 025 | 7 895 | 8 330 | 8 380 | 8 275 | 8 225 | 7 710 | 7 825 | 7 245 | 7 115 | 7 280 |
| 2014 | 7 980 | 7 775 | 8 425 | 8 370 | 8 685 | 8 730 | 7 955 | 7 590 | 7 635 | 7 550 | 7 495 | 7 465 |
| 2015 | 7 415 | 7 565 | 7 810 | 8 080 | 8 145 | 8 445 | 7 985 | 7 230 | 7 005 | 5 975 | 5 620 | 5 520 |
| 2016 | 6 165 | 6 875 | 7 105 | 8 170 | 8 495 | 7 930 | 6 950 | 6 865 | 6 120 | 5 235 | 5 495 | 5 580 |
| 2017 | 6 775 | 7 405 | 7 785 | 7 985 | 8 230 | 7 905 | 7 725 | 7 375 | 7 250 | 6 945 | 6 710 | 6 505 |
| 2018 | 6 615 | 7 110 | 7 740 | 8 365 | 8 465 | 8 735 | 9 085 | 8 225 | 7 780 | 7 845 | 8 005 | 8 305 |
| 2019 | 8745* | | | | | | | | | | | |

**Хонины ястай мах**

| | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2013 | 6 480 | 7 095 | 7 060 | 7 420 | 7 490 | 7 470 | 7 415 | 6 710 | 6 540 | 6 215 | 6 085 | 6 245 |
| 2014 | 6 855 | 6 675 | 7 040 | 7 630 | 7 800 | 7 685 | 7 030 | 6 585 | 6 395 | 5 965 | 5 835 | 5 940 |
| 2015 | 5 860 | 6 140 | 6 735 | 7 460 | 7 555 | 7 455 | 6 830 | 6 050 | 5 540 | 4 510 | 4 200 | 3 930 |
| 2016 | 4 625 | 5 495 | 5 970 | 6 935 | 6 945 | 6 525 | 5 780 | 5 605 | 4 940 | 4 250 | 3 945 | 4 390 |
| 2017 | 5 650 | 6 030 | 6 675 | 7 080 | 7 235 | 6 700 | 6 575 | 6 395 | 6 210 | 5 760 | 5 380 | 5 140 |
| 2018 | 5 240 | 5 945 | 6 560 | 7 290 | 7 490 | 7 515 | 7 535 | 6 980 | 6 415 | 6 440 | 6 690 | 6 695 |
| 2019 | 6980* | | | | | | | | | | | |

* 2-р долоо хоногийн ажиглалтаар

Зураг 2. Хонины махны дундаж үнэ, 1 кг




Өмнөх долоо хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 25 төгрөгөөр (0.4%), хонины цул махны үнэ 185 төгрөгөөр (2.5%) өссөн байв. Энэ долоо хоногийн ажиглалтаар хонины мах "Хархорин" хүнсний захад хамгийн хямд буюу 6300 төгрөгөөр, харин "Таван-Эрдэнэ" хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 8000 төгрөгөөр худалдаалж байна.

## Гурилын үнэ



2019 оны I сарын 2-р долоо хоногт нийслэлийн хүнсний томоохон зах, дэлгүүрт "Алтан тариа" савласан нэг кг гурилын үнэ дээд зэрэг нь 1250-1500 төгрөг, 1-р зэргийнх 1000-1200 төгрөг, 2-р зэргийнх 800-1000 төгрөг байна.

Худалдан авагч олон байдаг "Хүчит шонхор", "Таван эрдэнэ", "Бөмбөгөр", "Баянзүрх", "Хархорин" хүнсний захуудад задгайгаар буюу шуудайгаар худалдаж буй нэг кг дээд зэргийн "Алтан тариа" гурилын үнэ 1250-1400 төгрөгийн үнэ ханштай байна. Харин "Барс" хүнсний захад дээд зэргийн "Алтан тариа" гурил 1250 төгрөг, 1-р зэргийн гурил 950 төгрөгөөр тус тус зарагдаж байна.

Зураг 3. Будааны үнэ, 1 кг




Зураг 4. Савласан гурилын үнэ, 1кг






“Атар” талх хүнсний зах, дэлгүүрт 1200-1320 төгрөгийн үнэтэй байна. “Баянзүрх”, “Бөмбөгөр”, “Барс”, “Хархорин” хүнсний захуудад “Атар” талхыг хамгийн хямд буюу 1200 төгрөгөөр, харин “Сансар” супермаркетад хамгийн өндөр үнээр буюу 1320 төгрөгөөр худалдаалж байна.

## Хүнсний ногооны үнэ

2019 оны I сарын 2-р долоо хоногт өмнөх долоо хоногтой харьцуулахад монгол төмс 1.2 хувиар өсөж 825 төгрөгөөр, лууван 0.5 хувиар өсөж 1090 төгрөгөөр, байцай 9.3 хувиар өсөж 1175 төгрөгөөр, хүрэн манжин 10.8 хувиар өсөж 1535 төгрөгөөр тус тус худалдаалагдаж байна.

Зураг 5. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, төгрөг




## Хэрэглээний үнийн ажиглалтын хавсралт хүснэгт:

Хавсралт 1. Хүнсний барааны үнийн ажиглалт, хүнсний зах, худалдааны төвөөр, 2019.I.09

Хавсралт 2. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2018 оны X, XI, XII сар, 2019 оны I сар

Хавсралт 3. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2013-2019 оны I сарын 09

Хавсралт 4. Хэвийн боов, хонины ууцны дундаж үнэ, 2019.I.09

Хавсралт 5. Шатахуун, түлшний үнэ, ШТС-аар, 2019.I.09

Хавсралт 6. Шатахууны үнийн зэрэгцүүлэлт, 2018 оны X, XI, XII сар, 2019 оны I сарын ажиглалтаар

Хавсралт 7. Шатахууны үнэ өөрчлөгдсөн өдөр, 2018 он

Хавсралт 8. Түлшний дундаж үнэ, худалдаж буй байршлаар, 2019.I.09